

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД
ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ
БУУРУУЛАХ, ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮР
АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТЫН КОД: /ДУА-2025/07-10-ШТА-НА/

Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох
Утас: 70592439

Аудитын менежер Т.Батсайхан
Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Ж.Угтахбаяр

Аудитор Д.Должинсүрэн, Б.Мягмарсүрэн,
Э.Пүрэвбаатар, У.Хоролмаа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2025 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/29

Мандалговь

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.5, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.1, 1.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Аймгийн 2026 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах” нийцлийн аудитын тайлан (ДУА-2025/07-10-ШТА-НА)-г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийцлийн аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2026 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын нэгдүгээр нэгжийн ахлах аудитор (Ж.Угтахбаяр)-д үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Аудитын тайланг баталгаажуулах тухай	
	Товчилсон үгс	4
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-7
	<u>БҮЛЭГ 1. Төсвийн төсөлд хэт өндрөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн орлогуудад анхаарах, зарим орлогыг төвлөрүүлэхтэй холбоотой хууль журмын хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна.</u>	
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	1.1 УИХ-аас нийт орлогыг 46,245.2 сая төгрөгөөр баталсан бол аймгаас 10,498.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 56,743.6 сая төгрөгийн орлого оруулахаар санал гаргасан байна.	8-9
	1.2 Түрээсийн орлогын 60 хувь буюу өөрийн орлогыг 151.7 сая төгрөгөөр, орон нутгийн орлогод нэмэгдэх 40 хувь буюу түрээсийн орлогыг 85.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.	9-10
Аудитын менежер Т.Батсайхан	1.3 Түгээмэл тархацтай бүх төрлийн ашигт малтмалаас орох орлогыг хууль, журмын дагуу ашиглах нөхцөл бүрдээгүй байна.	10-11
Ахлах аудитор Ж.Угтахбаяр	1.4 Газрын дуудлага худалдааны орлогыг төлөвлөхдөө хэдэн байршилд, ямар зориулалтаар дуудлага худалдааг зохион байгуулах талаар тооцоо, судалгаа хийгээгүй байна.	11-12
Аудитор Д.Должинсүрэн	1.5 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг бүрэн төвлөрүүлэх арга хэрэгслийг оновчтой сонгосноор орлого бүрэн төвлөрч, орлогын төлөвлөгөөг 92.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.	12-15
Б.Мягмарсүрэн	1.6 Хувь хүний орлогын албан татварын орлогын төлөвлөгөө жил бүр давж биелж байгаа нь ирэх онд нэмэгдэх цалин хөлс, нэмэгдлийг тооцдоггүйтэй холбоотой байна.	15-17
Э.Пүрэвбаатар	1.7 Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлд үндэслэн нэмэгдүүлэх боломжтой байна.	17-18
У.Хоролмаа	<u>БҮЛЭГ 2. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ нь тооцоо судалгаанд үндэслээгүй, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүй, үр дүнд сүүрилсэн төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна</u>	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.		
<u>ХАЯГ:</u>		
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн		

удирдлагын ордон, 213
тоот

2024 оны 11 дүгээр сар

2.1.Орон нутгийн төсвийн зардлыг төлөвлөхдөө арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлохгүй, зураг төсөвгүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй зэрэг нийтлэг алдаа дутагдал байгаа нь зардлыг бодитой бус төлөвлөх эрсдэлийг бий болгож байна. **19-20**

2.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хууль, журмын дагуу төлөвлөөгүй байна . **20-21**

2.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөр, арга хэмжээ төлөвлөлтийн шаардлага хангахгүй байна . **21-22**

2.4 Сангийн яамнаас гаргасан чиглэлийн дагуу бүтэц орон тоог бууруулахаар төсөвлөсөн байна. **22-23**

Дүгнэлт

Зөвлөмж

Хавсралт

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БОАЖС	Байгаль орчин аялал жуучлалын сайд
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг Даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНТ	Орон нутгийн төсөв
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их Хурал
ЦТСС	Цахилгаан түгээх салбар сүлжээ

<p><i>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</i></p> <p><i>Аудитын зорилго, зорилт:</i></p> <p><i>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:</i></p> <p><i>Аудитын хамарсан хүрээ:</i></p>	<p style="text-align: center;">АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ын дагуу 2024 оны А/107 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө.</p> <p>Аймгийн Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал дүгнэлт гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">▪ Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх санал гаргах▪ Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд төсвийн зарлагыг бууруулах, үр ашгийг дээшлүүлэх санал гаргах <p>Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none">▪ Монгол Улсын Үндсэн хууль;▪ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;▪ Төсвийн тухай хууль;▪ Төрийн аудитын тухай хууль;▪ Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль;▪ Төсвийн төсөл боловсруулах удирдамж▪ Татварын багц хуулиуд;▪ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;▪ Бусад холбогдох хууль, тогтоомж, журам, зааврууд. <p>Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, аймгийн Татварын хэлтэс, бусад төсвийн байгууллагуудыг хамруулан, 2026 оны төсвийн төсөл, 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, хүлээгдэж байгаа гүйцэтгэл, тайлант онд хийсэн төсвийн тодотгол, зохицуулалт хийсэн материал, судалгаа болон татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой бусад холбогдох баримт материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.</p>
--	---

<p><i>Аудитын арга зүй:</i></p>	<p>Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн А/67 тоот тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.</p> <p>Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Т.Батсайхан аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитын нэгдүгээр нэгж тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2025 оны 11 сарын 21-ны өдрөөс 11 сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэлээ.</p>
<p><i>Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа</i></p>	<p>Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 6.3.2¹-т заасан бүрэн эрхийн хүрээнд жил бүр орон нутгийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал дүгнэлт гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлдэг.</p>
<p><i>Үндсэн мэдээлэл</i></p>	<p>Сүүлийн жилүүдийн төсвийн төсөлд:</p> <ul style="list-style-type: none">2023 оны төсвийн төсөлд орлогын 2 төрөлд 115.0 сая төгрөгийг нэмэгдүүлэх, 5 төрөлд орлого нэмэгдүүлэх, бүрдүүлэх боломжийг судалж үзэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, зардал бууруулах төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх 6 санал хүргүүлсэн. Үүнээс 356.0 сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлэн, зөрчилтэй 1,570.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төсвийн төслөөс хасуулсан.

¹ Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал, Засгийн газар болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх;

	<ul style="list-style-type: none"> ▪ 2024 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх 1,510.7 сая төгрөг, бүрэн төвлөрүүлэх орлого 350.0 сая төгрөг, зардал хэмнэх 240.1 сая төгрөг, зардлын эх үүсвэр бий болгох 67.9 сая төгрөгийн санал хүргүүлсэн. Мөн аудитын тайлангаар сумдын Засаг дарга нарт 2, аймгийн Засаг даргад 8 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн. Төрийн аудитын газрын зөвлөмжийн дагуу зөрчилтэй 940.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвийн төслөөс хасуулж, зөрчлийг арилгасан. Малын тоо толгойн албан татварыг бэлчээрийн даацтай уялдуулан тогтоож, орлогыг төлөвлөн, сумдын ИТХ-ын тогтоолоор батлан, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг 1,547.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэв. Дулааны эрчим хүч үйлдвэрлэгч байгууллагатай халаалтын гэрээг шинэчлэн хийснээр сард 34.3 сая төгрөг, жилдээ 240.1 сая төгрөгийн түлш халаалтын зардлыг хэмнэх боломжтой бөгөөд тооцооллыг зөвлөмжийн хамт аймгийн Засаг даргад хүргүүллээ. Төсвийн төсөлд өгсөн саналын хүрээнд нийт 1,547.4 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэв. ▪ 2025 онд төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлтээр 19,424.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулах 3.1 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, үр ашгийг нэмэгдүүлэх 8 заалт 19,420.9 сая төгрөгийн зөвлөмжийг аймгийн засаг даргад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан аудитаар нийт 0.2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэв.
<p style="text-align: center;">Аудитын дүн</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Аудитаар нийт 10,636.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 284.1 сая төгрөгийн алдааг залруулж, орлого нэмэгдүүлэх 330.4 сая төгрөгийн 2 санал, бодитой төлөвлөөгүй орлого бууруулах 5,000.0 сая төгрөгийн 1 санал, Аймгийн Засаг даргад 5,022.0 сая төгрөгийн 6 заалт бүхий зөвлөмж, Сумдын засаг дарга нарт 4 заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.




БҮЛЭГ 1. Төсвийн төсөлд хэт өндрөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн орлогуудад анхаарах, зарим орлогыг төвлөрүүлэхтэй холбоотой хууль журмын хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна.

1.1. УИХ-аас нийт орлогыг 46,245.2 сая төгрөгөөр баталсан бол аймгаас 10,498.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 56,743.6 сая төгрөгийн орлого оруулах санал гаргасан байна.

Дундговь аймгийн 2026 оны төсвийн төсөлд төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийг 70,987.5 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оноос 23,640.0 сая төгрөгөөр буюу 25.0 хувиар буурсан байна. Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийн 577.0 сая төгрөг буюу 0.8 хувь нь улсын төсвөөс аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс, 32,892.9 сая төгрөг буюу 46.3 хувийг аймгийн татварын болон татварын бус орлогоос, 12,403.0 сая төгрөг буюу 17.5 хувь нь орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдлээс, 13,480.7 сая төгрөг буюу 19.0 хувь нь улсын төсвөөс аймгийн төсөвт авах орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээс, 11,633.9 сая төгрөг буюу 16.4 хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

График №1 Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэр



Аймгийн 2026 оны төсвийн орлогыг 56,743.6 сая төгрөг байхаар төлөвлөсөн нь өмнөх оноос 256.8 сая төгрөг буюу 0.5 хувиар буурсан байна. Тус орлогын 20,343.4 сая төгрөг буюу 35.9 хувийг сумдын төвлөрсөн, үлдсэн 36,400.2 сая төгрөг буюу 64.1 хувийг аймгийн төвлөрсөн төсвийн орлогоор бүрдүүлэхээр тус тус төлөвлөжээ.

2026 оны төсвийн орлогыг УИХ-аас 46,245.2 сая төгрөгөөр баталсныг аймгаас 7 нэр төрлийн 10,498.4 сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлж, нийт төсвийн орлогыг 56,743.6 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна. Үүнд:

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 14,600.0 сая төгрөг;
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг 360.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 540.0 сая төгрөг;
- Газрын төлбөрийг 548.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,860.0 сая төгрөг;
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 103.0 сая төгрөг;
- Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 70.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 420.0 сая төгрөг;
- Бусад орлогыг 3,500.0 сая төгрөг;
- Газрын дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын орлого 4,920.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 5,040.0 сая төгрөг байхаар тус тус төлөвлөсөн байна.

Аймгийн 2026 оны төсвийн төслийн орлогын төлөвлөгөөнд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 14,600.0

сая төгрөгөөр төсөвлөгдсөн нь 2025 оноос 1,970.0 сая төгрөг буюу 15.5 хувиар нэмэгдүүлсэн байна. Энэ нь эрүүл мэнд, боловсролын салбарын ажилтнуудын цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үе шаттайгаар нэмэгдүүлэн олгохтой холбоотой байна.

Мөн дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын орлого 5,040.0 сая төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд 2025 оноос 4,740.0 сая төгрөгөөр буюу 15.8 дахин нэмэгдүүлсэн байна. Тус орлогыг хөгжлийн 4 замын уулзварт газар дахин төлөвлөж, дуудлага худалдаа зохион байгуулахаар төлөвлөсөнтэй холбоотой байна.

Бусад орлогын төлөвлөгөөг 3,500.0 сая төгрөгөөр төсөвлөсөн нь тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудтай хуулийн дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд гэрээ байгуулснаар хандиваар бий болгоно гэж үзжээ. Гэвч хэдэн тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэдэн төгрөгийн гэрээ байгуулж, орлого төвлөрүүлэх нь тодорхойгүй байгаа нь орлогын төлөвлөгөө биелэхгүй байх эрсдлийг бий болгож байна.

Аймгийн төсвөөс Гурвансайхан сумын дэд бүтэц, Сайнцагаан, Эрдэнэдалай сумын цэвэрлэх байгууламжуудын үндсэн зээл болон хүүгийн төлбөрт нийт 534.1 сая төгрөгийг 2026 онд төлөхөөр төсвийн зардалд тусгаж, орлогын эх үүсвэр дээр дамжуулан зээлдүүлэхийн хүүгийн орлого 534.1 сая төгрөгийн орлогыг төлөвлөсөн ч ямар эх үүсвэрээс төвлөрүүлэх нь тодорхойгүй байсаар байна. Иймд зээл, хүүгийн төлбөрт төлөх эх үүсвэрийг бодитоор төлөвлөх шаардлагатай байна.

1.2. Түрээсийн орлогын 60 хувь буюу өөрийн орлогыг 151.7 сая төгрөгөөр, орон нутгийн орлогод нэмэгдэх 40 хувь буюу түрээсийн орлогыг 85.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээ” зааврын 1.7-т (Үйл ажиллагааны үндсэн чиглэлээс бусад зориулалтаар байр талбайг бусдад эзэмшүүлж ашиглуулахад түрээсийн гэрээ байгуулж, түрээсийн орлогоос 40 хувийг орон нутгийн орлогод төвлөрүүлнэ) заасан байна.

Харин 2026 оны төсвийн төсөлд зөвхөн аймгийн ЗДТГ дээр түрээсийн орлогын 60 хувь буюу өөрийн орлогыг 7.0 сая төгрөгөөр төсөвлөж, үлдэгдэл 40 хувь болох түрээсийн орлогыг 20.0 сая төгрөгөөр тусгасан нь төсвийн тооцооллын уялдаагүй, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 43.0 /50.0-7.0/ сая төгрөгөөр дутуу төсөвлөсөн байна.

Аудитаар орон нутгийн төсөвт байгууллагуудад бүртгэлтэй байгаа үндсэн хөрөнгөөс түрээслэх боломжтой хөрөнгийн судалгааг талбайн хэмжээ, зориулалтаар судаллаа. Судалгаагаар 5,983.5 м.кв талбайг жилийн хугацаанд бүрэн түрээслүүлбэл 300.3 сая төгрөгийн түрээсийн орлого бүрдүүлэхээс 40 хувь буюу 119.2 сая төгрөгийг орон нутагт төвлөрүүлж, 60 хувь буюу 181.1 сая төгрөгийг тухайн байгууллагууд өөрийн орлогоор хүлээн зөвшөөрөх боломжтой байна. /Хүснэгт №1/

Орон нутагт шаардлагатай нарийн мэргэжлийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор орон нутгийн өмчит 442.3 м.кв орон сууцыг 3 хүртэл жил үнэ төлбөргүй ашиглах ашиглалтын гэрээг хийсэн байна.

Аудитаар 2025 оны байдлаар нийт 264.5 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэх боломжтой байна. Үүнээс:

- Түрээсийн орлогын 40 хувьтай тэнцэх 105.8 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэн тусгавал, одоогийн төсөвт тусгагдсан 20.0 сая төгрөгийг хасч тооцоход 85.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
- Мөн түрээсийн орлогын 60 хувь болох 158.7 сая төгрөгийг тухайн байгууллагуудын өөрийн орлогод тусган төвлөрүүлэх шаардлагатай бөгөөд одоогийн батлагдсан 7.0 сая төгрөгтэй харьцуулахад 151.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлага байна.

Иймд дээрх тооцоололд үндэслэн орон нутгийн төсвийн орлого болон байгууллагуудын өөрийн орлогыг зохих хэмжээгээр нэмэгдүүлж төлөвлөх нь зүйтэй гэж үзэв.

Хүснэгт №1 Түрээслэх боломжтой хөрөнгийг түрээслэхэд төвлөрөх орлогын судалгаа

№	Түрээслэж буй эсэх	Түрээслүүлэх талбайн хэмжээ		Түрээсийн нийт дүн /мян.төг/	Жилийн төвлөрүүлэх (40%) дүн /мян.төг/
		Х.Н	(м2)		
1	Түрээслэж байгаа	м.кв	5,082.3	264.478.2	105,791.3
2	Ашиглалтын гэрээтэй	м.кв	442.3	15,219.7	6,087.9
3	Түрээслээгүй	м.кв	458.9	20,606.4	7,351.6
	Нийт дүн		5,983.5	300,304.3	119,230.7

Иймд төвлөрүүлэх боломжтой орлогын тооцоог төсөвт тусган, орон нутгийн өмчийг үр ашигтай захирч, хадгалалт хамгаалалтыг сайжруулан, эзэнтэй болгож бусдад түрээслүүлэн, эдийн засгийн эргэлтэд оруулж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх бүрэн боломж байна.

1.3.Түгээмэл тархацтай бүх төрлийн ашигт малтмалаас орох орлогыг хууль, журмын дагуу ашиглах нөхцөл бүрдээгүй байхад өндрөөр төлөвлөж байгаа нь төлөвлөгөөт орлого тасрах эрсдэлийг бий болгож байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогын төлөвлөгөөг 2026 оны төсвийн төсөлд 103.0 сая төгрөг байхаар тусгасан нь өмнөх оноос 91.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онуудтай харьцуулахад 2023-2025 онуудын төлөвлөгөө 49.2-91.1 хувиар тасарсаар байхад 2026 онд орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 8.5 дахин нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь төлөвлөгөө батлахдаа өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулаагүй, бодитой тооцоо судалгаанд үндэслээгүйг харуулж байна.

График №2 Түгээмэл тархацтай ашигт малтмал



2025 оны байдлаар аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 28 аж ахуй нэгж, байгууллага, Баянжаргалан, Дэлгэрхангай сумдад ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуй нэгж, байгууллага байна.

Өөрөөр хэлбэл хуульд заасан ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа аж, ахуйн нэгж байгууллага байхгүй нь орлогын төлөвлөгөө тасрах үндсэн шалтгаан болж байна.

Засгийн газраас 2025 оны 09 дүгээр сард 82 дугаар тогтоолоор улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой ач холбогдолтой авто замын бүтээн байгуулалтыг саадгүй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах тусгай журам баталсан. Тус журмаар түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн аймгийн Засаг дарга болон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч хуулийн этгээдтэй гүйцэтгэлийг үнэлэн төлбөр тооцож, орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр заасан байна.



Иймд холбогдох албан тушаалтнууд 2025-2026 онуудын авто замын засварын ажлын гүйцэтгэлийг үнэлэн тус журмын дагуу төлбөр авах, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1², тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1³-д заасны дагуу шаардлагатай сумдад хуулийн шаардлага хангасан аж, ахуйн нэгж байгууллагад ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

1.4. Газрын төлбөрийн орлогыг бодитой төлөвлөсөн ч дүүдлага худалдааны орлогыг төлөвлөхдөө хэдэн байриилд, ямар зориулалтаар зохион байгуулах талаар тооцоо, судалгаагүйгээр төлөвлөсөн байна.

Газрын төлбөрийн орлогыг 2024 онд 2,000.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 1,649.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж биелэлт 82.4 хувь буюу төлөвлөгөө тасарсан. 2025 онд 4,700.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж эхний 10 сарын байдлаар 1,364.9 сая орлогыг төвлөрүүлж гүйцэтгэл 29.0 хувийн биелэлттэй бөгөөд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2,909.3 сая төгрөгийн орлого төвлөрч төлөвлөгөөний гүйцэтгэл 61.9 хувь буюу 1,790.7 сая төгрөгөөр тасрахаар байна.

График №3. Газрын төлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэлийг харуулбал:



Газрын төлбөрийн орлогыг 2026 оны төсвийн төсөлд өмнөх оноос 60.4 хувиар бууруулж 1,860.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Энэ нь 2025 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн байдлаарх газар эзэмшиж, ашиглаж байгаа 7,850 иргэн, аж ахуй нэгж, байгууллагын мэдээлэл, өмнөх онуудын орлогын гүйцэтгэлд үндэслэн бодитой тооцон төлөвлөжээ.

² Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно

³ аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах

Харин газрын дуудлага худалдаанаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө сүүлийн жилүүдэд биелсэн бөгөөд 2025 оны 10 дугаар сарын байдлаар 2,352.6 сая төгрөг төвлөрсөн байна. Энэ нь сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжид 1,033.7 мянган м.кв талбай бүхий газрыг дуудлага худалдаагаар эзэмшүүлж, 2.167.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №2. Дуудлага худалдааны орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

Уг орлогыг 2026 оны төсвийн төсөлд өмнөх оноос 16.8 дахин нэмэгдүүлэн 5,040.0 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд зөвхөн дуудлага худалдаанаас 5,000.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт хувнар
2023	170.0	306.4	180.3
2024	200.0	244.7	122.3
2025	300.0	2,352.6	784.2
2026	5,040.0		

Дуудлага худалдааны орлогыг төлөвлөхдөө хэдэн байршилд, ямар зориулалтаар дуудлага худалдааг зохион байгуулах талаар тооцоо, судалгаагүй мөн дуудлага худалдаа оролцогчтой байж амжилттай болох эсэх нь тодорхойгүй байна. Энэ нь газрын дуудлага худалдааны орлого тасрах эрсдэлтэйг харуулж байна.

1.5. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг бүрэн төвлөрүүлэх арга хэрэгслийг оновчтой сонгосноор орлого бүрэн төвлөрч, орлогын төлөвлөгөөг 92.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөөг 2026 оны төсвийн төсөлд 210.0 сая төгрөг байхаар тусгасан нь өмнөх оноос 3.8 сая төгрөгөөр бууруулсан байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл 236.8 сая төгрөг буюу 110.8 хувьтай байна. Гүйцэтгэлийн өсөлтөд Говь-Угтаал, Луус, Өлзийт, Өндөршил, Баянжаргалан, Сайнцагаан, Цагаандэлгэр сумд голлон нөлөөлсөн байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр хураамжийн орлого давж биелэхээр байна. /Хавсралт №1/



Орлогын өсөлтийн гол шалтгаанууд нь:

- ✓ Говь-Угтаал (283.8%), Луус (183.1%), Сайнцагаан (119.2%) сумууд хуулийн дагуу айл өрхийн хог хаягдлын хураамжийг цахилгааны төлбөртэй хамтатган төвлөрүүлсэн.
- ✓ Баянжаргалан, Гурвансайхан, Өлзийт, Өндөршил сумууд уул уурхайн компаниудын хог хаягдлын үйлчилгээний хураамжийг бүрэн төвлөрүүлсэн.

Дээрх нөхцөл байдлаас харахад хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын гүйцэтгэл болон хүлээгдэж буй гүйцэтгэлийг харгалзан үзэлгүйгээр 2026 оны төсвийг үндэслэлгүй бууруулсан байна.

Тооцоо судалгаагүй хураамжийн орлогыг бууруулснаар орлого нэмэгдүүлэх бодит боломжийг хязгаарлаж, орлого нь биелчихсэн сумдын идэвхийг бууруулах сөрөг нөлөөтэй юм.

Аудитаар хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөөг цахилгаан түгээх сүлжээ (ЦТСС)-ийн цахилгааны төлбөр төлдөг хэрэглэгчид, сумдын ИТХ-аас баталсан тариф зэргийг үндэслэн төлөвлөсөн эсэхийг шалгалаа.

Хүснэгт №3 Айл өрхийн хог хаягдлын хураамжийн ногдуулалт

№	Эрчим хүчээр хангагч байгуул ага	Сумын нэр	Айл өрх						Хог хаягдлын хураамжийн орлого			
			Тариф			Тоо			Нийт дүн	Суутгасан шимтгэл	Төвлөрүүлэх боломжтой орлого	
			Нэг хүн	Гэр хороолол	Халаалт холбогдсон	Хүн амын тоо	Гэр хороолол	Халаалттай				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11=9-10		
1	Дундговь цахилгаан түгээх сүлжээ салбар	Адаацаг		3.0			227		8,172.0	1,634.4	6,537.6	
2		Гурвансайхан		3.0			226		8,136.0	1,627.2	6,508.8	
3		Луус		2.5					4,590.0	918.0	3,672.0	
4		Хулд		3.0					5,004.0	1,000.8	4,003.2	
5		Дэлгэрцогт		20.0					3,180.0	636.0	2,544.0	
6		Эрдэнэдалай		7.0					4,921.0	984.2	3,936.8	
7		Дэлгэрхангай		5.0	2.5			321	4	19,380.0	3,876.0	15,504.0
8		Сайнцагаан		3.0	2.0			2700	1952	144,048.0	28,809.6	115,238.4
9		Өлзийт		2.0	2.0			71	74	1,740.0	348.0	1,392.0
				6.0	3.0			71	74	3,888.0	777.6	3,110.4
10	Дэрэн	0.3				2087	177		7,513.2	1,502.6	6,010.6	
		Дүн				2087	4876	2030	210,572.2	42,114.4	168,457.8	
1	Эрдэнэ-булган	Сайхан-овоо		3.5	1.5		227	17	4,920.0	984.0	3,936.0	
				5.0	2.5		227	17	7,065.0	1,413.0	5,652.0	
		Дүн					227	17	11,985.0	2,397.0	9,588.0	
1	БЗӨБЦТ С төхк Говьсүмбэр	Өндөршил		1.5			278		5,004.0	1,050.8	3,953.2	
2		Говь-Угтаал		3.0			293		10,548.0	2,215.1	8,332.9	
3		Баянжаргалан		0.5	0.5		179		537.0	112.8	424.2	
4		Цагаандэлгэр	0.5				993	129		5,958.0	1,251.2	4,706.8
		Дүн				993	879		23,335.8	4,900.5	18,435.3	
		Нийт дүн				3080	5982	2047	245,893.0	49,412.0	196,481.0	

Хүснэгт №3-т нийт 15 сумын айл өрхийн тоо, тариф, ногдуулалтын дүн, үйлчилгээний шимтгэлийн суутгал болон төвлөрүүлж болох орлогын тооцоог харууллаа.

- Аймгийн хэмжээнд 15 сумын **8029 айл өрх** бүртгэлтэй. Үүнээс 5982 өрх гэр хороололд, 2047 айл өрх төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байна.
- Дэрэн, Цагаандэлгэр сумдын хувьд айл **өрхөөр бус** хүн амын тоонд суурилсан тариф хэрэгжүүлдэг тул 2024 оны тухайн сумын хүн амын статистик тоон мэдээллийг ашигласан.

Аудитын тооцооллоор айл өрхөөс хог хаягдлын хураамжийг бүрэн төвлөрүүлэхэд 246.8 сая төгрөг, үйлчилгээний шимтгэлд 49.5 сая төгрөгийг суутгуулан, 197.2 сая төгрөг буюу нийт 2026 оны төсвийн 93.9 хувийг зөвхөн айл өрхийн хураамжаар бүрэн бүрдүүлэх боломжтой байна.

Дундговь аймгийн 10 сумыг Дундговь цахилгаан түгээх сүлжээ салбар, 4 сумыг БЗӨБЦТ С ТӨХК Говьсүмбэр салбар, 1 сумыг Өвөрхангай аймгийн Эрдэнэ-Булган ЦТСС цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Аймгийн хэмжээнд 2025 онд Говь-Угтаал, Луус, Сайнцагаан сумууд ЦТСС-тай гэрээ хийн айл өрхийн хог хаягдлын хураамжийг бүрэн

төвлөрүүлж байгаа бол Баянжаргалан, Өлзийт, Өндөршил, Гурвансайхан сумд айл өрхөөс хураамжийг огт төвлөрүүлээгүй байна.

Иймд холбогдох ЦТСС-үүдтай бүх сум хог хаягдлын хураамжийг цахилгааны төлбөртэй хамтатган хураах гэрээ байгуулж, хураамжийн орлогыг бүрэн төвлөрүүлэн, үйлчилгээний шимтгэл 20-21 хувийг аймгийн хэмжээнд бууруулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

Харин ААНБ-аас хог хаягдлын хураамжийг бүрэн төвлөрүүлэх зорилгоор тооцоолол хийхэд, худалдаа, үйлчилгээ, зочид буудал, амралтын газар, зоогийн газар, үчин, гоо сайхан, оёдол, авто засвар зэрэг 867 ААНБ-ын хувьд нэгдсэн байдлаар тооцоолол хийж, татварын бааз суурийг сумдад бий болгоогүй байна. /Хавсралт № 2/

Иймд тооцоолол хийх боломжтой төсөвт байгууллага, уурын зуух, уул уурхай, зарим хураамж авдаг ААНБ-ын мэдээлэлд үндэслэн хураамжийн орлогыг тооцооллоо.

Аймгийн хэмжээнд цахилгаан хэрэглэж, үйл ажиллагаа явуулж буй нийт 1222 ААНБ бүртгэгдсэнээс 51.4 хувь буюу 629 ААНБ Сайнцагаан суманд, 48.6 хувь буюу 593 ААНБ үлдсэн 14 суманд үйл ажиллагаа явуулж байна.

Харин тооцоолол хийх боломжтой 355 ААНБ-ийн хураамжийг тооцоолж үзэхэд 106.4 сая төгрөгийг төвлөрүүлэх боломжтой байна. /Хавсралт №2/

Хүснэгт №4 ААНБ-ийн хог хаягдлын ногдуулалт

№	Сумын нэр	Төсөвт байгууллага	Уурын зуух	Уул уурхай	Бусад ААНБ	Төвлөрүүлэх боломжит дүн
1	Адаацаг	691.1	2,100.0	2,520.0	1,961.3	7,272.5
2	Баянжаргалан	314.2	300.0	12,090.0	748.0	13,452.2
3	Говь-Угтаал	600.0	700.0	1,200.0	3,810.0	6,310.0
4	Гурвансайхан	295.5	4,550.0	10,800.0	1,486.2	17,131.7
5	Дэлгэрхангай	592.0	700.0	2,610.2	584.2	4,486.4
6	Дэлгэрцогт	200.0	250.0	930.0		1,380.0
7	Дэрэн	751.8	630.0	-		1,381.8
8	Луус	420.0	1,050.0	-	1,728.0	3,198.0
9	Өлзийт	346.1	700.0	10,064.0		11,110.1
10	Өндөршил	600.0	350.0	10,500.0	150.0	11,600.0
11	Сайнцагаан	7,268.5	5,271.0	-	1,021.7	13,561.2
12	Сайхан-Овоо	455.4	1,938.9	-	5,353.9	7,748.1
13	Хулд	702.0	350.0	1,360.0	1,655.0	4,067.0
14	Цагаандэлгэр	288.0	48.0	-	504.0	840.0
15	Эрдэнэдалай	250.0	150.0	-	2,460.0	2,860.0
	Нийт дүн	13,774.6	19,087.9	52,074.2	21,462.2	106,398.9

Хүснэгтээс харахад ААНБ-ийн хог хаягдлын хураамжийн 48.9 хувь буюу 52.1 сая төгрөгийг хайгуулын болон ашиглалтын лицензтэй уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын орлогоос бүрдүүлэх боломжтой байна.



Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг бүрэн төвлөрүүлэх арга хэрэгслийг оновчтой сонгосноор орлого бүрэн төвлөрч, нийт орлогын төлөвлөгөөг 92.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна. /Хавсралт №3/

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд аймаг, сумын удирдлагууд *Хог хаягдлын тухай хуулийн 9.4.8⁴, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59-р зүйлийн 59.1.19⁵* заасан чиг үүргээ хэрэгжүүлж, ЦТСС-үүдтэй үйлчилгээний шимтгэлийн нөхцөлийг шинэчлэн тохиролцож, хураамжийн бодит орлогыг нэмэгдүүлэх тал дээр анхааран, ЦТСС-тай хамтран ажиллах шаардлагатай байна.

Мөн хураамжийн ногдуулалт хийгдээгүй ААНБ-ийн мэдээллийн бааз суурийг бий болгох мөн малчид болон мал бүхий иргэдээс байгаль орчны байцаагчаар хураамжийн ногдуулалтыг хийлгэж, татварын байцаагчаар цахим системд нэхэмжлэл үүсгүүлэн, хог хаягдлын хураамжийг бүрэн төвлөрүүлж, төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Мөн тухайн онд УТХО, ОНХО, ОНХС болон хувийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга, байгууламж, шугам сүлжээний хог хаягдалд хяналт тавьж, хог хаягдлын хураамжийн ногдуулалтыг хийн, төсөвт хураамжийг бүрэн төвлөрүүлж байх шаардлагатай байна.

1.8 Хувь хүний орлогын албан татварын орлогот ирэх онд нэмэгдэх цалин, нэмэгдэл хөлсийг оруулж тооцсон байна.

Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварын төлөвлөгөөг 2026 оны төсвийн төсөлд Сангийн яамнаас баталсан төсвийг 1,000.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 14,600.0 сая төгрөг байхаар төлөвлөсөн нь өмнөх оноос 1,970.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт №5-аас харахад Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварын 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл 12,943.8 сая төгрөг буюу 102.5 хувьтай байна.

Хүснэгт №5. ХХОАТ-ын 2025 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2026 оны төсөв

Сумын нэр	Жилийн төлөвлөгөө	2025 он				2026 он		
		Төлөвлөгөө /1-10 сар/	Гүйцэтгэл /1-10 сар/	ХБГүйц /11,12 сар/	Жилийн ХБГ	Төсөв	Өөрчлөлт	
1	Дэлгэрцогт сум	218.4	160.3	185.5	37.1	222.7	249.0	30.6
2	Дэрэн сум	231.0	180.0	213.9	42.8	256.7	280.0	49.0
3	Говь-Угтаал сум	354.4	271.0	293.8	58.8	352.5	379.0	24.6
4	Цагаандэлгэр сум	159.7	127.7	191.9	38.4	230.3	247.0	87.4
5	Баянжаргалан сум	270.3	213.3	288.9	57.8	346.6	473.0	202.7
6	Өндөршил сум	245.2	192.2	226.3	45.3	271.6	301.0	55.8
7	Гурвансайхан сум	1,146.4	799.7	918.1	183.6	1,101.7	1,370.0	223.6
8	Өлзийт сум	250.6	183.5	234.6	46.9	281.5	316.0	65.4
9	Хулд сум	276.2	213.0	205.1	41.0	246.1	279.0	2.8
10	Луус сум	205.8	156.0	205.3	41.1	246.3	277.0	71.2
11	Дэлгэрхангай сум	450.4	335.1	717.6	143.5	861.2	906.0	455.6
12	Сайхан-Овоо сум	234.9	184.0	227.8	45.6	273.4	302.0	67.1
13	Эрдэнэдалай сум	597.6	444.0	489.4	97.9	587.3	677.0	79.4
14	Сайнцагаан сум	7,715.5	5,675.5	6,129.0	1,225.8	7,354.8	8,192.0	476.5
15	Адаацаг сум	273.7	217.0	259.2	51.8	311.0	352.0	78.3
	Орлогын дүн	12,630.0	9,352.2	10,786.5	2,157.3	12,943.8	14,600.0	1,970.0

⁴ байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих

⁵ нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах

Аудитаар сум, байгууллагуудаас авсан боловсрол, эрүүл мэндийн салбарын ТҮЭМ, ТҮБД ангилал, зэрэглэлийн албан хаагч нарын цалингийн судалгаанд үндэслэн бодитой төлөвлөсөн эсэхийг тулган баталгаажууллаа. Үүнд.

- 15 сумдын ЭМТ, Сургууль, Цэцэрлэг
- Аймгийн төвийн ЭМБ-ууд /Нэгдсэн эмнэлэг, УАУТ, ЗӨСТ, ӨЭМТ/ хамрагдлаа.


2026 оны төсвийн саналыг 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулж өөрчлөлтийг авч үзвэл:

- ✓ Боловсрол, эрүүл мэндийн салбарын цалин нэмэгдэхээр тооцсон 1380 албан хаагчийн цалин, нэмэгдлийг тооцоолсон ХХОАТ-ын дүнгээр сумдын татварын орлогыг 1,088.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. /Хавсралт №4/
- ✓ Зарим сумдад үйл ажиллагаа эрхэлж байгаа уул, уурхайн компаниудын цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварын орлогыг тухайн орон нутагт төвлөрүүлэхээр тооцож нэмэгдүүлсэн. Үүнд:
 - Баянжаргалан:- 100.0 сая /Үнэн анд ХХК, Уулс мандал ХХК/
 - Гурвансайхан:- 200.0 сая /Эрдэнэс алт ресурс ХХК-ы туслан гүйцэтгэгч 4 ХХК/ байна.

2026 оны цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварын орлогыг 2025 оны бодит гүйцэтгэл болон хүлээгдэж буй гүйцэтгэлийг харгалзан үзэж, сумдын орлогын төлөвлөгөөг 5-15 хүртэл хувиар нэмэгдүүлсэн байна. /Хавсралт №4/

Аудитаар Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварыг сүүлийн 4 жилийн гүйцэтгэлд хийсэн судалгаагаар аймгийн хэмжээнд тус татвар 14-21 хувиар давж биелсэн үзүүлэлттэй байна.

Энэ нь сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудын цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварыг Төсвийн тухай



хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ” 23.8.17-д “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар” заалтын дагуу тухайн суманд төвлөрүүлж тайлагнаж эхэлснээр тус албан татварын төлөвлөгөө давж биелсэн нь дараах үзүүлэлтээс харагдаж байна. /Хавсралт №5/

Мөн 2025 оны төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс Дэрэн (0.3%), Говь-Угтаал (9.6%), Цагаандэлгэр (7.6%) Баянжаргалан (14.6%) Луус (1.3%) Дэлгэрхангай (13.9%) бууруулж баталснаар цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварын төлөвлөгөө давж биелсэн үзүүлэлттэй байна. /Хүснэгт №6/

Хүснэгт №6. Батлагдсан төсвийг өмнөх оны гүйцэтгэлд харьцуулсан судалгаа

№	Орлогын төрөл	2022 он	2023 он	өсөлт, бууралт /хувиар/	2023 он	2024 он	өсөлт, бууралт /хувиар/	2024 он	2025 он	өсөлт, бууралт /хувиар/
		Гүйц	Төл		Гүйц	Төл		Гүйц	Төл	
1	Дэлгэрцогт сум	94.9	113.8	19.9%	126.8	191.1	50.7%	195.6	218.4	11.7%
2	Дэрэн сум	107.6	125.5	16.6%	146.9	177.0	20.5%	231.7	231.0	-0.3%
3	Говь-Угтаал сум	148.7	168.0	13.0%	180.8	221.0	22.2%	392.1	354.4	-9.6%
4	Цагаандэлгэр сум	79.4	94.9	19.4%	109.7	130.0	18.6%	172.7	159.7	-7.6%
5	Баянжаргалан сум	100.1	118.0	17.9%	168.9	198.7	17.7%	316.6	270.3	-14.6%
6	Өндөршил сум	113.6	127.5	12.3%	155.4	175.7	13.1%	233.2	245.2	5.1%
7	Гурвансайхан сум	125.0	380.4	204.2%	497.3	893.0	79.6%	1,102.0	1,146.4	4.0%
8	Өлзийт сум	106.9	124.9	16.8%	144.5	206.7	43.0%	248.3	250.6	1.0%
9	Хулд сум	115.5	131.4	13.8%	167.6	227.8	35.9%	265.7	276.2	3.9%
10	Луус сум	104.1	114.5	9.9%	139.1	171.5	23.3%	208.6	205.8	-1.3%
11	Дэлгэрхангай сум	149.0	168.1	12.8%	194.2	265.0	36.4%	523.2	450.4	-13.9%
12	Сайхан-Овоо сум	106.9	126.5	18.3%	154.9	206.8	33.5%	234.2	234.9	0.3%
13	Эрдэнэдалай сум	230.9	260.5	12.8%	335.6	500.2	49.0%	532.8	597.6	12.2%
14	Сайнцагаан сум	3,376.4	4,058.8	20.2%	4,417.5	5,797.1	31.2%	6,681.4	7,715.5	15.5%
15	Адаацаг сум	119.3	136.2	14.2%	168.6	217.4	28.9%	261.7	273.7	4.6%
	Нийт орлогын дүн	5,078.4	6,249.0	23.1%	7,107.7	9,579.0	34.8%	11,599.5	12,630.0	8.9%

Дээрх нөхцөл байдлаас харахад өмнөх жилүүдэд Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварын сумдын орлогын төлөвлөгөөг батлахдаа урьд оны гүйцэтгэлтэй уялдуулаагүй, бодитой тооцоо судалгаанд үндэслээгүйгээс орлогын төлөвлөгөө жил бүр давж биелсэн үзүүлэлттэй гарч байсан. Харин 2026 оны цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварын орлогыг нэмэгдүүлсэн дүн нь бодитой тооцоололд үндэслэсэн байна.

1.9 Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогын төлөвлөгөөг гүйцэтгэл болон ногдуулалтад түлгүүрлан нэмэгдүүлсэн нь үндэслэлтэй байна.

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогын төлөвлөгөөг 2026 оны төсвийн төсөлд 540.0 сая төгрөг байхаар төлөвлөсөн нь өмнөх оноос 279.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл 412.2 сая төгрөг буюу 157.9 хувьтай байна. Гүйцэтгэлийн өсөлтөд Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ” 23.8.16-д “энэ хуулийн 23.6.11-т зааснаас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар” заалтын дагуу 2025 оноос Гурвансайхан сумын нутагт үйл ажиллагаа эрхэлдэг “Эрдэнэс алт ресурс” ХХК-ы үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг тухайн сумын орлогот төвлөрүүлснээр орлогын төлөвлөгөө 167.2 сая төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна. /Хавсралт №6/

Сүүлийн 4 жилийн гүйцэтгэлд хийсэн судалгаагаар 2022 онд орлогын төлөвлөгөө өмнөх жилүүдээс өндөр дүнгээр хянагдаж батлагдсанаар 10 хувиар тасарч, 2023 онд суурь түвшинг бууруулснаар 13 хувиар, 2024 онд 38 хувиар, 2025 онд 32 хувиар аймгийн хэмжээнд татварын орлого давж биелсэн үзүүлэлттэй байна.

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогын төлөвлөгөөг 2025 онд төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэлээс 6 хувиар бууруулан баталсан бөгөөд зарим сумдын татварын орлогын төлөвлөгөө өмнөх оны гүйцэтгэлээс 2-33 хувиар нэмэгдүүлж, 3 сумын татварын орлогыг 4-30 хувиар бууруулж харилцан адилгүй баталсан, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт, Сайхан-Овоо сумдын татварын орлогын төлөвлөгөө 10 сарын байдлаар давж биелсэн зэргээс үзэхэд өмнөх онуудад төлөвлөгөө батлахдаа урьд оны гүйцэтгэлтэй уялдуулаагүй, бодитой тооцоо судалгаанд үндэслээгүйг харуулж байна. /Хавсралт №6/

Харин Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг төлөвлөхдөө 2025 оны бодит гүйцэтгэл болон хүлээгдэж буй гүйцэтгэл, хөрөнгийн үнэлгээний өсөлт бууралтыг тооцож төлөвлөсөн байна.

Сумдын 2026 оны Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогын төлөвлөгөөг ногдуулалт болон өмнөх оны гүйцэтгэлд суурилан 540.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь үндэслэлтэй байна гэж үзлээ.

Үл хөдлөх хөрөнгийн албан татварын 4 жилийн үзүүлэлт






БҮЛЭГ 2. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ нь тооцоо судалгаанд үндэслээгүй, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүй, үр дүнд суурилсан төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна.

2.1. Орон нутгийн төсвийн зардлыг төлөвлөхдөө арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлохгүй, зураг төсөвгүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй зэрэг нийтлэг алдаа дутагдал байгаа нь зардлыг бодитой бүс төлөвлөх эрсдэлийг бий болгож байна.

График №6 Төсвийн зарлагын харьцуулалт

Аймгийн 2026 оны орон нутгийн төсвийн зарлагыг 70,987.5 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна. Энэ нь 2025 оны төсвийн зарлагаас 23,640.0 сая төгрөг буюу 25.0 хувиар буурсан байна. Нийт зардлын 50,715.5 сая төгрөг буюу 71.4 хувийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад, 10,696.5 сая төгрөг буюу 15.1 хувийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас сумын төсвийн ерөнхийлөн захирагчид олгох санхүүгийн дэмжлэг, 9,575.6 сая төгрөг буюу 13.5 хувийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас сумын төсвийн ерөнхийлөн захирагчид олгох орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг эзэлж байна.



сумын төсвийн ерөнхийлөн захирагчид олгох санхүүгийн дэмжлэг, 9,575.6 сая төгрөг буюу 13.5 хувийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас сумын төсвийн ерөнхийлөн захирагчид олгох орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг эзэлж байна.

Техник хяналтын сан 66.7 хувь, замын сан 19.7 хувь, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал 84.7 хувь, мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардал 21.2 хувиар нэмэгдсэн нь хамгийн их өсөлттэй зардлууд байна.

Нийтлэг үйлчилгээний урсгал зардалд зарцуулахаар 700.0 сая төгрөгийг төсөвлөсөн байна. Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.3⁶, 35.1.12⁷-д зааснаар Засаг даргын үйл ажиллагааг дэмжих ОНӨААТҮГ байгуулахаар төлөвлөсөнтэй холбоотой байна.

Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2,581.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь өмнөх оноос 451.0 сая төгрөг нэмэгдсэн байна. Энэ нь аймгийн хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөтэй нийцсэн байна.

Улсын төсвийн байгууллагуудын албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг өмнөх онд 1,631.7 сая төгрөгөөр төлөвлөж байсан бол 2026 оны төсвийн төсөлд хассан байна.

⁶ Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно

⁷ орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг бүрэн гаргаагүй байна.

2.2.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хууль, журмын дагуу төлөвлөхгүй байна.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.5⁸, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтууд, аймгийн Засаг даргын тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулж төлөвлөсөн байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд нийт 42 ширхэг 18,208.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээс өмнөх онд хийгдсэн ажлыг үргэлжлүүлэхэд 8,325.4 сая төгрөгийн, шинээр барилга угсралт, их засварт 2,331.6 сая төгрөг, тоног төхөөрөмжид 20.0 сая төгрөг, төсөл хөтөлбөр арга хэмжээнд 6,487.0 сая төгрөгийн, замын сангийн хөрөнгөөр 1,044.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Эдгээр ажлуудыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7

ОНТ-өөс санхүүжих хөрөнгийн задаргаа /сая төгрөг/

№	Үзүүлэлт	ОНХО	Их засвар	Замын сангийн хөрөнгөөр	Дүн	Эзлэх хувь
1	Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ	7,896.1	429.3		8,325.4	45.7
2	Барилга угсралт, их засвар	2,331.7			2,331.7	12.8
3	Тоног төхөөрөмж	20.0			20.0	0.1
4	Төсөл, хөтөлбөр арга хэмжээ	4,128.9	2,358.1		6,487.0	35.6
5	Зам засвар, арчилгаа			1,044.0	1,044.0	5.7
	НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	14,376.7	2,787.4	1,044.0	18,208.1	100.0
1	2025 оны ОНХО-ын шилжих	7,896.1	56.2		7,952.3	43.7
2	2025 оны хэмнэлт	464.6	339.2		803.8	4.4
3	2026 оны ОНТ-өөс санхүүжих	6,016.0	2,392.0	1,044.0	9,452.0	51.9
	НИЙТ ЭХ ҮҮСВЭР	14,376.7	2,787.4	1,044.0	18,208.1	100.0

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө төсвийн эх үүсвэр тодорхойгүй 190.0 сая төгрөгийн албан хэрэгцээнд ашиглах тоног төхөөрөмжийг тусгасан байна.

Мөн батлагдсан зураг, төсөв, эдийн засгийн тооцоо судалгаагүй, магадлалын нэгдсэн дүгнэлтгүй, төсөл арга хэмжээг тусгасан байна. Үүнийг төсөл арга хэмжээний нэрээр харуулбал:

Хүснэгт №8 /сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	2026 онд санхүүжигдэх	Тайлбар
1	Хөгжлийн төвийн шинэ барилга /Цагаандэлгэр сум/	811.2	ЭЗ-ийн тооцоо судалгаагүй, магадлалын дүгнэлтгүй
2	Сайнцагаан сум 7-р баг Их тойруу-9 гудамжны гадна дулаан хангамжийн ажил	366.0	Зураг, төсөвгүй

⁸ тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх

3	Хуучин 5-р сургуулийн барилгыг 20 айлын орон сууц болгох	790.0	Зураг, төсөвгүй
Нийт дүн		1,967.2	

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2⁹, Барилгын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2¹⁰, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3.2¹¹-т заасныг тус тус зөрчсөн байна.

2.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөр, арга хэмжээ төлөвлөлтийн шаардлага хангахгүй байна.

2026 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 10,975.7 сая төгрөгийн 30 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Үүнээс 2025 оноос шилжсэн 1,477.1 сая төгрөгийн 10, шинээр хэрэгжүүлэх 9,498.6 сая төгрөгийн 20 хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, төсөл, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөвлөсөн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажлын төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт: №9 ОНХС-ийн төсөв, эзлэх хувь /сая төгрөг/

№	Үзүүлэлт	ОНХС	Эзлэх хувь
1	Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ	1,477.1	13.5%
2	Барилга угсралт, их засвар	5,864.5	53.4%
3	Тоног төхөөрөмж	2,536.9	23.1%
4	Төсөл, хөтөлбөр арга хэмжээ	1,097.2	10.0%
	НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	10,975.7	100.0%
1	2025 оны ОНХС-аас шилжих	2,313.4	21.1%
2	2025 оны хэмнэлт	1,257.1	11.5%
3	2026 оны ОНХС-аас санхүүжих	3,905.2	35.6%
4	Бусад эх үүсвэр	3,500.0	31.9%
	НИЙТ ЭХ ҮҮСВЭР	10,975.7	100.0%

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын иргэдийн саналаар дэмжигдсэн байдлын хувьд урьдчилсан жагсаалтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд танилцуулан санал авч нэгтгэхдээ боловсролын байгууллагын албан хаагч, төрийн албан хаагч болон иргэд, хүүхдүүдэд танилцуулсан тухай нотлох баримтыг ирүүлсэн.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулж төлөвлөсөн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төлөвлөсөн ажлуудаас дараах барилга, их засвар болон зураг төсөв боловсруулах ажлууд төлөвлөлтийн шаардлага хангахгүй байна.

- Өмнөх оноос шилжих хөрөнгө оруулалтад тусгагдсан “Малчны хөгжлийг дэмжих төвийн зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах” ажлын төсөвт өртөг 188.2 сая төгрөгөөр гэрээ байгуулагдаж 2023-2024 онуудад нийт 150.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байхад 2026 онд санхүүжигдэх төсөвт өртгийг 94.1 сая төгрөгөөр илүү буюу 131.7 сая төгрөгөөр тооцсон байна.

⁹ Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна

¹⁰ Барилга байгууламжийн магадлал хийгдсэн иж бүрэн зураг төсөл, магадлалын дүгнэлт

¹¹ Төсвийн хязгаарт багтсан, нэн тэргүүний ач холбогдолтой байх

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй 956.1 сая төгрөгийн өртөгтэй “*Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн гэрэлтүүлэг хийх*” ажлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, урьдчилсан тооцоо судалгаа нь хийгдээгүй, хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргаагүй байна.
- 1,000.0 сая төгрөгийн өртөгтэй “*Сайнцагаан сум 7-р баг Их тойруу-9 гудамжны гадна дулаан хангамжийн ажил*” нь зураг, төсөв байхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2.4¹²-т, 29 дүгээр зүйл 29.2¹³ дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3¹⁴-т заасан шаардлагад тус тус нийцэхгүй байна.

Баталгаажсан зураг төсөв, тооцоо судалгаагүй хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн нь хууль тогтоомж зөрчих, төлөвлөсөн ажил хугацаандаа хэрэгжихгүй байх, улмаар өөр хэрэгцээ шаардлагатай, ач холбогдолтой хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх боломжийг хааж сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх үр дагавартай байна.

Иймд зураг төсөв, магадлалын нэгдсэн дүгнэлт, эдийн засгийн тооцоо судалгаагүйгээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хуульд заасны дагуу төсөвлөлтийн шаардлагыг хангуулах шаардлагатай байна.

2.4 Сангийн яамнаас гаргасан чиглэлийн дагуу бүтэц орон тоог 9 хувиар бууруулж, төсвийг төсөвлөсөн байна

Дундговь аймгийн ТЕЗ буюу Засаг даргын харьяа нийт 37 төсөвт байгууллагын нийт 510 орон тоотой батлагдсанаас 2025 оны 10 сарын байдлаар 54 ажлын байр сул байна. Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн дагуу орон тоог 9 хувиар бууруулахаар баталсны дагуу тооцоолоход 48 албан хаагчийг цомтголд оруулахаар байна. /Хүснэгт №10/

№	Байгууллагын нэр	2025 оны суурь орон тоо	2025 оны тодотголоор хассан	2026 оны орон тооны хязгаар
1	Аймгийн ИТХ	10	1	9
2	Сумдын ИТХ	46	4	42
3	АЗДТГ	74	7	64
4	Архивын хэлтэс			3
5	Сумдын ЗДТГ	337	31	306
6	Худалдан авах ажиллагааны газар	7	1	6
7	Орон нутгийн өмчийн газар	8	1	7

¹² өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;

¹³ Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

¹⁴ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хууль заасны дагуу зураг төсөв, техникийн эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх.

8	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	7	1	6
9	Ойн анги	5	0	5
10	Байгаль орчны газар	26	2	24
	Нийт дүн	520	48	472

Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу ТЕЗ өөрийн эрх мэдлийн хүрээнд төсөвт байгууллага хооронд зохицуулалт хийж болохоор заасан тул 48 сул орон тоог бууруулсан байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг бүрэн тодорхойлоогүй.
2. Аймгийн төсвөөс Гурвансайхан сумын дэд бүтэц, Сайнцагаан, Эрдэнэдалай сумын цэвэрлэх байгууламжуудын үндсэн зээл болон хүүгийн төлбөрт нийт 534.1 сая төгрөгийг 2026 онд төлөхөөр төсвийн зардалд тусгаж, орлогын эх үүсвэр дээр дамжуулан зээлдүүлэхийн хүүгийн орлого 534.1 сая төгрөгийн орлогыг төлөвлөсөн ч ямар эх үүсвэрээс төвлөрүүлэх нь тодорхойгүй байна.
3. Түрээсийн орлогын 60 хувь буюу өөрийн орлогыг 151.7 сая төгрөгөөр, орон нутгийн орлогод нэмэгдэх 40 хувь буюу түрээсийн орлогыг 85.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
4. Түрээслэх боломжтой хөрөнгийн нэгдсэн жагсаалт, мэдээллийн санг бий болгоогүй байна.
5. Түгээмэл тархацтай ашигт малтмалаас орох орлогыг хууль, журмын дагуу бүрдүүлэх боломж бүрдээгүй байхад төлөвлөж байгаа нь төлөвлөгөөт орлого тасрах эрсдэлийг бий болгож байна.
6. Дуудлага худалдааны орлогыг төлөвлөхдөө хэдэн байршилд, ямар зориулалтаар дуудлага худалдааг зохион байгуулах талаар тооцоо, судалгаагүйгээр төлөвлөсөн.
7. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг бүрэн төвлөрүүлэх арга хэрэгслийг оновчтой сонгосноор орлого бүрэн төвлөрч, орлогын төлөвлөгөөг 91.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
8. ЦТСС-ууд хог хаягдлын хураамжийн орлогын төвлөрүүлэлтээс 20-21 хувийн үйлчилгээний шимтгэлийг суутгаж байна.
9. Хувь хүний орлогын албан татварын орлогот ирэх онд нэмэгдэх цалин, нэмэгдэл хөлсийг оруулж тооцсон байна.
10. Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогын төлөвлөгөөг гүйцэтгэл болон ногдуулалтад тулгуурлан нэмэгдүүлсэн нь үндэслэлтэй байна.
11. Орон нутгийн төсвийн зардлыг төлөвлөхдөө арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлохгүй, зураг төсөвгүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй байгаа нь зардлыг бодитой бус төлөвлөх, төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлийг бий болгож байна.
12. Сангийн яамнаас гаргасан чиглэлийн дагуу бүтэц орон тоог 9 хувиар бууруулж, төсвийг төсөвлөсөн байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Аймгийн ТЕЗ-ийн 2026 оны хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг суурь түвшинд тулгуурлан бүрэн тодорхойлж ажиллах
2. Түрээслэх боломжтой хөрөнгийн нэгдсэн жагсаалт, мэдээллийн санг бий болгож, олон нийтэд нээлттэй болгон, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулж, түрээсийн орлогыг нэмэгдүүлэх;
3. Дуудлага худалдааны орлогыг төлөвлөхдөө хэдэн байршилд, ямар зориулалтаар зохион байгуулах талаар тооцоо, судалгаа хийх;
4. Аймгийн Засаг дарга хог хаягдлын хураамжийн орлогын төвлөрүүлэлтийн 20-21 хувийн үйлчилгээний шимтгэлийг боломжит хэмжээнд буулгах талаар ажил зохион байгуулж ажиллах;
5. Эрх бүхий албан тушаалтнууд бүрэн эрхийн хүрээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд заасан шаардлагын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага бий болгох нөхцөл боломжоор хангаж, орлогыг үндэслэлтэй төлөвлөх;
6. Нийгмийн хариуцлагын гэрээний орлого олохтой холбоотой тооцоо судалгаа хийж, үндэслэлтэй төлөвлөх;
7. Эх үүсвэр тодорхойгүй төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх;
8. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээг техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулж, судалгаа шинжилгээ хийж, эрэмбэлэн, нэн тэргүүний ач холбогдлыг тодорхойлж, жагсаалт гарган, үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлтийг гаргаж орон нутгийн төсөвт тусгуулах;

Сумдын Засаг дарга нарт:

1. Сумд БОАЖС-ын 2018 оны 192, А/243 дугаартай “Аргачлал батлах тухай” хамтарсан тушаалын аргачлалын дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ, энгийн хог хаягдлыг цэвэрлэх цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг аргачлалын дагуу бодитой тооцож, тарифаа шинэчлэн тогтоох;
2. Хог хаягдлын тухай хуулийн 41.7-д зааснаар үлдсэн 12 сумын төвийн айл өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг цахилгааны төлбөртэй хамтатган авч төвлөрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, хураамжийн төлөлтөд хяналт тавьж, тооцоо нийлж баталгаажуулах замаар орлогыг бүрэн төвлөрүүлэх;

3. Суманд ААНБ-ын хог хаягдлын хураамжийн бааз суурийг нэмэгдүүлж, малчид болон мал бүхий иргэд, үйл ажиллагаа явуулж байгаа бүх ААНБ-аас хог хаягдлын хураамжийг бүрэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;
4. Тухайн онд шинээр баригдаж байгаа барилга байгууламж, шугам сүлжээний хог хаягдалд тухай бүр хяналт тавьж, хураамжийг бүрэн ноогдуулан төвлөрүүлж байх.



Санал, тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг даргад танилцуулж санал тайлбарыг авлаа.



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-213 тоот, 7 дугаар баг,
Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090 Утас: 7059 2353
Цахим шуудан: info@dundgovi.gov.mn,
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2025. 12. 01 № 01 / 1609
танай 2025. 12. 01 -ны № 01 / 192

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Дундговь аймгийн 2026 оны төсвийн төсөл”-д хийсэн аудитын санал дүгнэлтийн төсөлтэй танилцаж, төсвийн төсөлд боломжтой саналыг хүлээж авлаа.

Тайлангийн төсөлд хариу тайлбар байхгүй болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Ц.АРИУНБАЯР

4825146754

/Хавсралт №1/ Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн 2025 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2026 оны төсөв

Сумын нэр	2025 он					2026 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /10 хүртэл/	Хувь	Хүлээгдэж буй гүйцэтгэл	Хувь	Төсөв	Өөрчлөлт
1	2	3	4	5	6	7	8=5-7
Адаацаг	9,600.0	6,809.6	70.9	8,609.6	89.7	9,500.0	890.4
Баянжаргалан	14,000.0	7,090.0	50.6	15,490.0	110.6	8,000.0	(7,490.0)
Говь-Угтаал	3,000.0	7,914.4	263.8	8,514.4	283.8	5,500.0	(3,014.4)
Гурвансайхан	10,000.0	9,000.0	90.0	13,350.0	133.5	10,500.0	(2,850.0)
Дэлгэрхангай	3,000.0	2,376.4	79.2	2,876.4	95.9	3,000.0	123.6
Дэлгэрцогт	4,500.0	2,786.9	61.9	3,586.9	79.7	4,500.0	913.1
Дэрэн	5,000.0	3,741.7	74.8	4,741.7	94.8	4,200.0	(541.7)
Луус	1,300.0	2,130.4	163.9	2,380.4	183.1	3,000.0	619.6
Өлзийт	4,000.0	9,472.0	236.8	10,622.0	265.6	9,000.0	(1,622.0)
Өндөршил	7,000.0	8,862.0	126.6	10,262.0	146.6	8,500.0	(1,762.0)
Сайнцагаан	113,900.0	112,644.4	98.9	135,744.4	119.2	120,500.0	(15,244.4)
Сайхан-Овоо	18,000.0	4,142.0	23.0	8,942.0	49.7	10,000.0	1,058.0
Хулд	10,000.0	2,895.8	29.0	7,180.8	71.8	3,000.0	(4,180.8)
Цагаандэлгэр	1,500.0	1,202.0	80.1	1,562.0	104.1	1,800.0	238.0
Эрдэнэдалай	9,000.0	287.0	3.2	2,987.0	33.2	9,000.0	6,013.0
Нийт дүн	213,800.0	181,354.6	84.8	236,849.6	110.8	210,000.0	(26,849.6)

/Хавсралт №2/ Үйл ажиллагаа явуулж байгаа хог хаягдлын хураамж төлөх боломжтой ААНБ судалгаа

№	Сумын нэр	Цахилгаан эрчим хүч төлдөг	Тооцоолсон				Хогны хураамж тооцоолоогүй ААНБ
			Төсөвт байгууллага	Уурын зуух	Уул уурхай	Татвар ногдуулдаг	
1	Адаацаг	42	6	1	2	18	15
2	Баянжаргалан	49	5		12	13	19
3	Говь-Угтаал	27	5	1	1	20	0
4	Гурвансайхан	33	5	1	3	22	2
5	Дэлгэрхангай	48	5	1	4	2	36
6	Дэлгэрцогт	33	5	1		8	19
7	Дэрэн	31	5	1			25
8	Луус	41	5	1		12	23
9	Өлзийт	27	5	1	7		14
10	Өндөршил	63	5	1	7	2	48
11	Сайнцагаан	629	63	2			564
12	Сайхан-Овоо	33	5	1		27	0
13	Хулд	44	5	1	3	9	26
14	Цагаандэлгэр	34	5	1		6	22
15	Эрдэнэдалай	88	6	1		27	54
		1222	135	15	39	166	867

/Хавсралт №3/ 2026 оны төсөв, аудитын тооцооллоор гарсан орох боломжтой хог хаягдлын судалгаа

/мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	2026 оны төсөв	Төвлөрүүлэх боломжтой дүн	Нэмэгдүүлэх дүн /зөрүү/	Айл өрх	Төсөвт байгууллага	Уурын зуух	Уул уурхай	ААНБ /ногдуулалт хийгдсэн/
1	Адаацаг	9,500.0	13,810.1	4,310.1	6,537.6	691.1	2,100.0	2,520.0	1,961.3
2	Баянжаргалан	8,000.0	14,894.6	6,894.6	1,442.4	314.2	300.0	12,090.0	748.0
3	Говь-Угтаал	5,500.0	14,642.9	9,142.9	8,332.9	600.0	700.0	1,200.0	3,810.0
4	Гурвансайхан	10,500.0	23,640.5	13,140.5	6,508.8	295.5	4,550.0	10,800.0	1,486.2
5	Дэлгэрхангай	3,000.0	19,990.4	16,990.4	15,504.0	592.0	700.0	2,610.2	584.2
6	Дэлгэрцогт	4,500.0	3,924.0	(576.0)	2,544.0	200.0	250.0	930.0	
7	Дэрэн	4,200.0	7,392.4	3,192.4	6,010.6	751.8	630.0	-	
8	Луус	3,000.0	6,870.0	3,870.0	3,672.0	420.0	1,050.0	-	1,728.0
9	Өлзийт	9,000.0	15,612.5	6,612.5	4,502.4	346.1	700.0	10,064.0	
10	Өндөршил	8,500.0	15,553.2	7,053.2	3,953.2	600.0	350.0	10,500.0	150.0
11	Сайнцагаан	120,500.0	128,799.6	8,299.6	115,238.4	7,268.5	5,271.0	-	1,021.7
12	Сайхан-Овоо	10,000.0	17,336.1	7,336.1	9,588.0	455.4	1,938.9	-	5,353.9
13	Хулд	3,000.0	8,070.2	5,070.2	4,003.2	702.0	350.0	1,360.0	1,655.0
14	Цагаандэлгэр	1,800.0	5,546.8	3,746.8	4,706.8	288.0	48.0	-	504.0
15	Эрдэнэдалай	9,000.0	6,796.8	(2,203.2)	3,936.8	250.0	150.0	-	2,460.0
	Нийт дүн	210,000.0	302,880.0	92,880.0	196,481.0	13,774.6	19,087.9	52,074.2	21,462.2

/Хавсралт №4/. Боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалингийн нэмэгдлийн тооцоолол

/мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	Албан хаагчийн тоо	2025 оны ХБГ		2026 оны тооцсон дүн		ХХОАТ зөрүү	2026 он		Зөрүү
			Жилийн нийт цалин	Тооцсон ХХОАТ	Жилийн нийт цалин	Тооцсон ХХОАТ		Тооцсон төсөв	Төсвийн санал	
1	Дэлгэрцогт сум	43	1,322,992.8	117,084.9	1,654,895.1	146,458.2	29,373.3	252,032.7	249,000.0	(3,032.7)
2	Дэрэн сум	45	1,543,470.0	136,597.1	1,940,535.9	171,737.4	35,140.3	291,815.8	280,000.0	(11,815.8)
3	Говь-Угтаал сум	42	1,276,456.8	112,966.4	1,621,270.6	143,482.4	30,516.0	383,046.0	379,000.0	(4,046.0)
4	Цагаандэлгэр сум	35	1,163,953.2	103,009.9	1,441,401.7	127,564.0	24,554.2	254,877.4	247,000.0	(7,877.4)
5	Баянжаргалан сум	38	1,349,448.0	119,426.1	1,681,125.4	148,779.6	29,353.5	475,983.1	473,000.0	(2,983.1)
6	Өндөршил сум	47	1,561,825.2	138,221.5	1,988,548.4	175,986.5	37,765.0	309,350.0	301,000.0	(8,350.0)
7	Гурвансайхан сум	45	1,577,019.6	139,566.2	1,948,198.0	172,415.5	32,849.3	1,334,509.6	1,370,000.0	35,490.4
8	Өлзийт сум	43	1,755,784.8	155,387.0	2,169,401.6	191,992.0	36,605.1	318,107.1	316,000.0	(2,107.1)
9	Хулд сум	43	1,330,575.6	117,755.9	1,706,665.8	151,039.9	33,284.0	279,415.6	279,000.0	(415.6)
10	Луус сум	41	1,360,261.2	120,383.1	1,684,399.0	149,069.3	28,686.2	275,022.3	277,000.0	1,977.7
11	Дэлгэрхангай сум	56	2,023,437.6	179,074.2	2,711,478.6	239,965.9	60,891.6	922,066.7	906,000.0	(16,066.7)
12	Сайхан-Овоо сум	41	1,336,611.6	118,290.1	1,697,989.4	150,272.1	31,981.9	305,368.9	302,000.0	(3,368.9)
13	Эрдэнэдалай сум	139	4,511,342.4	399,253.8	5,973,727.6	528,674.9	129,421.1	716,759.4	677,000.0	(39,759.4)
14	Адаацаг сум	54	1,979,283.6	175,166.6	2,505,416.4	221,729.4	46,562.8	357,551.0	352,000.0	(5,551.0)
15	Сайнцагаан сум	668	21,906,355.2	1,938,712.4	27,570,500.2	2,439,989.3	501,276.8	8,156,114.2	8,192,000.0	35,885.8
	НИЙТ ДҮН	1380	45,998,817.6	4,070,895.4	58,295,553.5	5,159,156.5	1,088,261.1	14,632,019.9	14,600,000.0	(32,019.9)

/Хавсралт №5/ Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварын төлөвлөгөөний биелэлт

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	2023 он			2024 он			2025 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Төлөвлөгөө	ХБГ	зөрүү
Дэлгэрцогт сум	113,800.0	126,833.8	13,033.8	191,100.0	195,561.5	4,461.5	218,385.0	222,659.4	4,274.4
Дэрэн сум	125,500.0	146,865.7	21,365.7	177,000.0	231,671.0	54,671.0	230,985.0	256,675.4	25,690.4
Говь-Угтаал сум	168,000.5	180,778.5	12,778.0	221,000.0	392,082.9	171,082.9	354,405.0	352,530.0	(1,875.0)
Цагаандэлгэр сум	94,900.0	109,654.4	14,754.4	130,000.0	172,688.6	42,688.6	159,650.0	230,323.2	70,673.2
Баянжаргалан сум	118,000.0	168,872.5	50,872.5	198,700.0	316,600.8	117,900.8	270,305.0	346,629.6	76,324.6
Өндөршил сум	127,500.0	155,361.8	27,861.8	175,700.0	233,199.5	57,499.5	245,180.0	271,585.0	26,405.0
Гурвансайхан сум	380,406.5	497,267.4	116,860.9	893,000.0	1,101,979.2	208,979.2	1,146,365.0	1,101,660.4	(44,704.6)
Өлзийт сум	124,880.0	144,540.8	19,660.8	206,700.0	248,270.0	41,570.0	250,645.0	281,502.0	30,857.0
Хулд сум	131,400.0	167,587.9	36,187.9	227,800.0	265,724.9	37,924.9	276,200.0	246,131.6	(30,068.4)
Луус сум	114,500.0	139,064.8	24,564.8	171,500.0	208,560.2	37,060.2	205,805.0	246,336.1	40,531.1
Дэлгэрхангай сум	168,116.0	194,247.1	26,131.1	265,000.0	523,170.1	258,170.1	450,375.0	861,175.1	410,800.1
Сайхан-Овоо сум	126,500.0	154,851.2	28,351.2	206,800.0	234,184.0	27,384.0	234,875.0	273,387.0	38,512.0
Эрдэнэдалай сум	260,500.5	335,647.7	75,147.2	500,200.0	532,780.9	32,580.9	597,618.0	587,338.3	(10,279.7)
Сайнцагаан сум	4,058,815.0	4,417,471.0	358,656.0	5,797,100.0	6,681,368.6	884,268.6	7,715,500.0	7,401,459.3	(314,040.7)
Адаацаг сум	136,188.0	168,640.0	32,452.0	217,400.0	261,678.8	44,278.8	273,707.0	310,988.3	37,281.3
Нийт дүн	6,249,006.5	7,107,684.6	858,678.1	9,579,000.0	11,599,521.0	2,020,521.0	12,630,000.0	12,990,380.7	360,380.7

/Хавсралт №6/ Үл хөдлөх хөрөнгийн албан татварын 2025 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2026 оны төсөв

/мянган төгрөгөөр/

ОРЛОГЫН ТӨРСӨЛ		2023 он		2024 он		2025 оны бат/төл	2025 он				2026 он
		Төл	Гүйц	Төл	Гүйц		Төл /1-10 сар/	Гүйц /1- 10 сар/	11,12 сарын ХБГ	Жилийн ХБГ	
Орон нутгийн төсвийн орлого		151,080.0	170,710.3	201,400.0	277,924.9	261,000.0	189,761.0	345,193.2	70,027.9	412,200.1	540,000.0
I	Сумын төвлөрсөн	151,080.0	155,525.7	201,400.0	265,721.3	261,000.0	189,761.0	341,819.6	68,517.4	410,337.0	540,000.0
1	Дэлгэрцогт сум	1,800.0	2,857.9	2,400.0	3,323.9	3,500.0	2,625.0	1,469.4	2,030.6	3,500.0	3,100.0
2	Дэрэн сум	1,700.0	1,936.5	1,800.0	1,931.0	2,100.0	1,575.0	1,211.8	888.2	2,100.0	2,200.0
3	Говь-Угтаал сум	1,900.0	1,850.9	1,900.0	1,873.6	2,500.0	1,700.0	322.9	2,177.1	2,500.0	124,000.0
4	Цагаандэлгэр сум	1,320.0	1,791.3	1,300.0	1,667.0	1,700.0	1,260.0	973.3	726.7	1,700.0	600.0
5	Баянжаргалан сум	2,100.0	2,277.9	2,200.0	3,562.2	4,000.0	3,000.0	2,384.8	1,615.2	4,000.0	3,200.0
6	Өндөршил сум	1,600.0	1,363.6	1,500.0	2,250.4	2,600.0	2,380.0	2,719.2	-	2,719.2	2,200.0
7	Гурвансайхан сум	25,600.0	26,751.5	28,500.0	33,211.5	42,000.0	21,970.0	189,217.8	-	189,217.8	194,000.0
8	Өлзийт сум	1,200.0	2,037.7	1,500.0	2,303.4	2,500.0	1,850.0	3,563.3	-	3,563.3	4,200.0
9	Хулд сум	2,600.0	2,344.6	2,800.0	3,302.5	3,500.0	2,621.0	1,882.7	1,617.3	3,500.0	2,500.0
10	Луус сум	2,300.0	3,712.4	2,900.0	5,742.7	4,000.0	3,050.0	2,375.8	1,624.2	4,000.0	2,900.0
11	Дэлгэрхангай сум	1,600.0	3,323.5	2,000.0	2,938.4	3,200.0	2,400.0	951.5	2,248.5	3,200.0	1,100.0
12	Сайхан-Овоо сум	1,400.0	2,148.1	3,500.0	3,504.4	3,500.0	3,030.0	4,436.7	-	4,436.7	5,700.0
13	Эрдэнэдалай сум	4,800.0	5,718.0	5,500.0	10,981.7	12,000.0	9,500.0	7,026.4	4,973.6	12,000.0	8,600.0
14	Сайнцагаан сум	97,560.0	92,889.2	140,000.0	183,707.0	168,700.0	129,000.0	120,720.8	47,979.2	168,700.0	181,800.0
15	Адаацаг сум	3,600.0	4,522.7	3,600.0	5,421.6	5,200.0	3,800.0	2,563.2	2,636.8	5,200.0	3,900.0
II	Аймгийн төвлөрсөн	-	15,184.6	-	12,203.6	-	-	3,373.6	1,510.5	1,863.1	-
1	Мандалговь	-	15,184.6	-	11,262.7	-	-	3,364.3	1,510.5	1,853.8	
2	Сумдаас	-	-	-	940.9	-	-	9.3	-	9.3	

